



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2020 оны 09 сарын 29 өдөр

Дугаар А/Н/М/1

Арвайхээр

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.2.а, 29.2, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны “Аймгийн төсөв батлах тухай” 12/09 дүгээр тогтоолын гуравдугаар хавсралтаар батлагдсан “2020 онд аймгийн төсвөөс санхүүжих хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээ, жагсаалтын 2 дахь заалтын дагуу Төрийн албанд автомашин худалдан авах, аймаг, сумдын төрийн байгууллагын автомашины засварын зардлыг хавсралтад заасны дагуу зарцуулсугай.

2.Төрийн байгууллагуудын авто машины засварт шаардагдах зардал 7300,000 (долоон сая гурван зуун мянга) төгрөгийг 2020 оны аймгийн төсвөөс санхүүжих хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний зардлаас гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Д.Нэмэхбаяр)-т зөвшөөрсүгэй.


ОРЛОГЧ



О.БАТЖАРГАЛ

011100967

Аймгийн Засаг даргын 2020 оны
09 дугаар сарын 29-ны өдрийн 447/1 дугаар
захирамжийн хавсралт



СУМДЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР, СОЁЛЫН
ТӨВИЙН АВТОМАШИНЫ ЗАСВАРТ ШААРДАГДАХ ЗАРДЛЫН
ХУВААРИЛАЛТ

№	Төсөл хөтөлбөр, арга хэмжээний нэр	Төсөвт өртөг /мян төг/
1	Баянгол сумын Засаг даргын Тамгын газрын машины засварт	5300.0
2	Гучин-Ус сумын Соёлын төвийн автомашины засварт	2000.0
	НИЙТ ДҮН	7300.0

-oOo-